

ЁС ЗҮЙН РЕЛЯТИВИЗМ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

Дэд профессор Г.Эрдэнэбаяр, доктор (Ph.D)

Дэд профессор Д.Оюунгэрэл, доктор (Ph.D)

МУИС, Философи, шашин судлалын тэнхим

Түлхүүр үг: *Соёлын ялгаа, харьцангуй байдал, ёс суртахуун, ёс суртахууны хэм хэмжээ*

Товч утга: *Энэхүү өгүүлэлд янз бүрийн соёлууд ёс суртахууны өөр өөр кодтой тухай өгүүлнэ. ХХ зууны 40-50-иад оны үед европ болон америкт нийгэм соёлын онол сэтгэлгээнд нэгэн чухал байр суурь бүхий чиглэл орж ирсэн нь соёлын релятивизм байв. Энэ нь улс үндэстэн бүрийн соёлын онцлогийг харгалзан үзэх, зарим ард түмний соёлыг зэрлэг, бүдүүлэг мэтээр доромжилсон агуулгаар хандахгүй байхыг уриалж, евроцентризм нь хэтэрхий явцуурч, туйлширч байгааг шүүмжилж гарч ирсэн. Энэ онолын төлөөлөгчид нь өрөөсгөл байдлаас зайлсхийх, соёл хоорондын ялгаатай байдлыг ойлгох, хүндэтгэлтэй хандах зорилгыг агуулсан ёс зүйн релятивист үзлийг сөргүүлэн тавьсан юм. Ёс зүйн релятивизмыг ойлгох, түүний агуулгыг хүлээн зөвшөөрөх өнцөг хаана байж болох вэ?*

Энэ үзэл санааг ярихын өмнө зарим соёл дахь өвөрмөц зан үйлийн хоёр жишээг авч үзье.

Жишээ 1. Эртний Персийн хаан Дариус аялах дуртай нэгэн байсан бөгөөд түүний сонирхлыг татдаг зүйл бол янз бүрийн соёл дахь зан үйлүүд байжээ. Жишээлбэл, Энэтхэгийн нэгэн овгийнхон болох каллатичууд нас барсан эцгийнхээ цогцсыг иддэг бол эртний грекчүүдийн хувьд чандарлах нь оршуулгын ёслолд хамгийн тохиромжтой арга гэж үздэг байв. Соёл хоорондын ялгаатай байдлыг хэрхэн үнэлэх нь түүний хувьд сонирхолтой байжээ (Rachels, 1998, p.15).

Грекчүүдийн хувьд нас барсан эцгийнхээ цогцсыг идэх нь байж боломгүй зүйл бол харин каллатичуудын хувьд нас барсан эцгийнхээ цогцсыг шатаах нь тэднийг гүн цочролд оруулах зүйл байв. Ингэхлээр янз бүрийн соёл дахь ёс суртахууны хэм хэмжээ өөр өөр байдаг байх нь. Нэг бүлгийн дотор зөв гэж үнэлэгдэж байгаа зүйл нь нөгөө бүлгийн хувьд буруу хэмээн үнэлэгдэж болох юм. Нас барсан хүний цогцсыг идэх үү эсвэл шатаах уу? Хэрэв та грек эсвэл каллати

хүн байсан бол хариулт мэдээж тодорхой.

Жишээ 2. 1996 онд Нью-Жерси дэх Ньюарк олон улсын нисэх онгоцны буудалд 17 настай Фаузия Кассинджа гэдэг охин орогнол хүссэн байна. Тэрээр өөрийн төрөлх Баруун Африкийн Того улсаас зугтаж ирсэнээ учирласан нь дараах шалтгаантай байв. Тус улсад охидын хэлүүг зүсэх мэс засал хийдэг байдал нэгэнт уламжлал болсон ажээ. Фаузия Кассинджа нь таван охинтой айлын отгон нь байв. Ачаа тээврийн ажил эрхэлдэг аав нь тус зан үйлийг эсэргүүцэж эхний дөрвөн охиноо зэрэмдэглүүлэхгүйгээр гэрлүүлж чадсан. Гэвч Фаузияг 16 настай байхад нь аав нь гэнэт нас баржээ. Ингэснээр тэр авга эгчийнхээ мэдэлд очиж, түүний зааснаар мэс ажилд орохоор болжээ. Фаузия айдаст автсан бөгөөд гэр бүлийн бусад гишүүд нь түүнийг оргон зугтаахад нь тусалсан байна. ... Барууны орнуудад үүнийг «эмэгтэй хүний бэлэг эрхтнийг зэрэмдэглэх» гэж нэрлэдэг. ДЭМБ-ын мэдээлснээр “Африкийн 29 улс оронд уг зан үйлийг хийдэг бөгөөд ойролцоогоор 125 сая эмэгтэй дээр хэрэгжсэн” (Rachels, 1998, p.25). байна.

Ёс суртахууны философид яригддаг нэг онол бол ёс зүйн релятивизм юм. Түүхийн хувьд МЭӨ V зууны үед Грекийн түүхч Геродот янз бүрийн нийгэм өөр өөр зан заншилтай байдаг бөгөөд хүн бүр өөрийн нийгмийн зан заншлыг хамгийн сайн гэж үздэг болохыг ажигласнаар энэхүү үзэл санааны үндсийг анх дэвшүүлжээ. Грекийн философич Протагорын (МЭӨ 481-420) “Хүн бол бүхний хэмжүүр» хэмээх ишлэлийг орчин үеийн социологичид, антропологичид онцолж тус онолын үндэслэл болгон тайлбарладаг ажээ. Мөн шинэ үеийн философич Б.Спиноза (1632-1677) юмс мөн чанараараа сайн, муу гэж байдаггүй болохыг онцлон тэмдэглэсэн.

Фридрих Ницше (1844–1900) үнэт зүйлс нь хүний зорилго болон өөртэй нь холбоотой байдаг тул бид өөрсдөө үнэт зүйлсийнхээ үнэ цэнийг үнэлэх ёстой гэж үздэг. Тэрээр ёс суртахууны үнэт зүйлс нь бидэнд хэр их нөлөө үзүүлж болохыг шинжлэх шаардлагатайг онцолжээ. Ницшегийн үзсэнээр, ёс суртахууны асуудал нь «сайн» гэж тооцогддог хүмүүс илүү боловсролтой, язгууртнууд байсан бөгөөд өөрсдийгөө өөрөөсөө доогуур хүмүүсээс илүү гэж үздэгт оршино. Тиймээс “сайн” гэж үнэлэгддэг зүйл нь харьцангуй юм. Бидний үйлдлийг захирч байсан ёс суртахууны ачаар хүн төрөлхтөн илүү сайн болсон. Гэхдээ сайн, муу гэж үздэг зүйл харьцангуй байдаг тул бидний тэдэнд өгөх ач холбогдол, үнэлэмж ч харьцангуй байх ёстой. Тэрээр ёс суртахуун нь өөрөө аюул учруулж болзошгүйг санал болгосон. Ницше үзэхдээ тодорхой бүлгийн гаргасан ёс суртахууны хуулиудад хариу үйлдэл үзүүлэхийн оронд бид хэн бэ, хувь хүнийхээ хувьд юуг үнэн, шударга, сайн, муу гэж юу гэж үздгээ харьцуулж, тэдгээрийг өөртөө идэвхтэйгээр төлөвшүүлэх ёстой гэжээ.

Соёлын харьцангуй байдал нь ёс зүйн релятивизмыг ойлгох гол түлхүүр болно.

Тэдний хувьд «Янз бүрийн соёлууд өөр өөр ёс суртахууны кодтой байдаг» гэх энэхүү үзэл санаа нь ёс суртахууныг ойлгох түлхүүр юм. Бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны үнэт зүйл гэж байдаггүй болохыг тэд онцолдог. Учир нь аль ч нийгмийн ёс заншил тухайн соёлынхоо оршин тогтнох үндэс болж байдаг. Аливаа нэг ёс заншил дахь зан үйлийг “зөв” эсвэл “буруу” гэж үнэлэх нь учир дутагдалтай хэмээн шүүмжилдэг. Үнэн хэрэгтээ аль нэг соёлд үнэлэлт дүгнэлт өгөх нь өөрсдийнхөө нүдээр, өөрийн соёлын жишгээр л бусдыг дүгнэж байгаа хэрэг болно. Бие даасан стандарт, бүхнийг шалгах шалгуур гэж байхгүй.

Ёс зүйн релятивизмийн талаарх маргаан нь ёс зүй, танин мэдэхүй, шинжлэх ухаан, шашин, улс төрийн онол, онтологи гээд философийн бараг бүх салбарыг хамардаг. Ёс зүйн релятивизм нь ёс суртахууны үнэлэлт дүгнэлтүүд нь түүнийг баримталдаг соёл, нийгэм, хувь хүнтэй харьцангуй холбоотой гэж үздэг ёс суртахууны философийн нэг онол юм. Өөрөөр хэлбэл, ёс зүйн релятивистууд зөв, буруу гэж үзсэн зүйл нь бүх нийтийнх биш, харин түүнийг үнэлж буй нөхцөл байдлаас хамаардаг гэж үздэг. Энэ үзэл нь зарим үйлдлүүд нь ямар ч соёл, нийгмийн нөхцөл байдлаас үл хамааран үргэлж зөв эсвэл буруу байдаг гэж үздэг ёс зүйн абсолютизмаас ялгаатай.

Ёс зүйн релятивизмыг дэмжсэн гол үндэслэлүүдийн нэг нь янз бүрийн соёл, нийгэм дэх ёс суртахууны итгэл үнэмшил, зан үйлийн олон янз байдлыг хүлээн зөвшөөрдөг явдал юм. Тухайлбал, зарим соёлд гэрлэхээсээ өмнө бэлгийн харьцаанд орохыг зөвшөөрдөг бол заримд нь энэ нь ёс суртахуунгүй зүйл байдаг. Цаашилбал, зарим нийгэмд цаазаар авах ялыг тодорхой гэмт хэрэгт оногдуулах шийтгэлийн нэг хэлбэр гэж үзэж байхад зарим нь нийгмийн сэтгэл зүйд хортой хүнлэг бус

шийтгэл, ёс суртахууны хувьд буруу зүйл гэж үздэг. Түүнчлэн цаазаар авах ялын хувьд философичдын, хуульчдын, шашны төлөөлөгчдийн, жирийн иргэдийн байр суурь ялгаатай бөгөөд нэгдмэл байр суурь баримтлахад төвөгтэй асуудлын нэг юм.

Ёс зүйн релятивистууд бүх хүнд, бүх цаг үед хамаарах ёс суртахууны нийтлэг нэг хэм хэмжээ байдаггүй, харин ёс суртахууны үнэлэмж нь янз бүрийн соёл, түүхийн хүчин зүйлсийн нөлөөгөөр тодорхойлогддог гэж үздэг. Жишээлбэл, амьтдад хандах хандлага нь соёл иргэншлээс хамаарч харилцан адилгүй байдаг. Нэг хэсэг нь “амьтныг сүнстэй, оюун ухаантай”(Ч.Баярчимэг, 2020, хууд.10) гэж үздэг бол өөр бусад философичид амьтдын ашиг сонирхол нь ёс суртахууны хүрээнээс гадуур оршдогийг батлахдаа тэднийг рационал сэтгэхүйгүй, ярих чадваргүй, эсвэл ердөө л хүн биш гэх нотолгоог мөн гаргаж тавьдаг байна. Өөрөөр хэлбэл, зарим нийгэм амьтдыг хоол хүнс, хүний амьдралыг хангах нөөц гэж үздэг бол зарим нь “тэдний эрхийн тухай асуудлыг гаргаж тавьж, хүний эрхийг хамгаалдгийн нэгэн адил хамгаалах ёстой”(Singer, p.53) гэж үздэг.

Ёс зүйн релятивизм нь нэлээд шүүмжлэлийг өөртөө дагуулдаг бөгөөд шүүмжлэгчид “энэ онол нь ёс суртахууны хөгжлийн боломжийг алдагдуулж, бусдын буруу үйлдлийг шүүмжлэхэд хэцүү болгодог” гэж үздэг. Жишээлбэл, хүн төрөлхтний түүхэнд арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, боолчлол, геноцид зэрэг үйлдлийг нь тодорхой соёл, нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн үе байсан. Хэрэв ёс зүйн релятивизмыг дөвийлгөх юм бол боолчлол, геноцид гэх мэт зан үйлийг ёс зүйн үүднээс шүүмжлэх боломжгүй болж, тэр бүх үйлдэл бүхэлдээ хүлээн зөвшөөрөгдөх

болно гэж тэд болгоомжилдог. Гэхдээ соёлын релятивистууд соёл хоорондын ялгаатай байдлыг ойлгож, түүнд хүлээцтэй ханддагаа нэн тэргүүнд чухалчилж үздэг нь уг онол дайн, хүчирхийлэл зэргийг үл тэвчих байдлыг дэмждэг гэвэл тун өрөөсгөл болно хэмээдэг.

Ёс суртахууны хувьд зөв бурууг тухайн нийгмийн хэм хэмжээ тогтоодог гэсэн шаардлага нь соёлын релятивизмын үндэс юм. Гэсэн хэдий ч бид бусад соёл иргэншлийн зарим зөвшөөргүй зан үйлийг үргэлж хүлцэн тэвчих ёстой үг биш юм. Бид тэдэнд үргэлж хүлцэнгүй хандах ёстой гэвэл өрөөсгөл зүйл байх болно.

Ёс зүйн релятивизмийн эерэг, сөрөг үр дагавар нь юу вэ?

Соёлын ялгаатай байдлын маргаан үндэслэлгүй байсан ч соёлын релятивизм нийгэмд тодорхой үүрэгтэй хэвээр байх магадлалтай. Тухайлбал,

1. Өөр бусад нийгмийн соёл, зан үйл нь ёс суртахууны хувьд биднийхээс доогуур гэж үнэлэхээ юуны өмнө азнах хэрэгтэй. Энэ нь «өөр» байсны төлөө буруутгагдах ёсгүй гэсэн санааг агуулна.
2. Ёс зүйн релятивист үзлийг хэтрүүлж үзвэл ёс суртахуунд сөрөг нөлөөтэй зарим үйлийг шүүмжлэх боломжгүй болно. Жишээлбэл, иргэдийнхээ шүүмжлэлт үзлийг хятадын засгийн газар ямагт буруушааж ирсэн түүхтэй. 1989 онд Тянь Ань Мэний талбайд тайван жагсаал хийсэн олон зуун жагсагчдыг хядсан¹. Үг хэлэх эрх чөлөөг дээдэлдэг нийгмийг хятадын нийгмээс илүү гэж хэлж чадахгүй байвал ямар вэ?
3. Бидний хийх ёстой зүйл бол ямарваа нэгэн үйл ажиллагаа нь тухайн нийгмийн

1. Амь үрэгдэгсдийн тоог хэн ч хэлж мэдэхгүй. Энэ хядлагын үеэр хэдэн мянган залуу амиа алдсаныг хэлэх нотлох баримт байхгүй. Хятадыг Засгийн газрын албаны мэдээгээр амь үрэгдэгсдийн тоог 241 гэж зарласан бол тус улс дахь Улаан Загалмайн нийгэмлэг 2600 гэдэг. Харин гадаадын сэтгүүлчдийн тооцоолсноор хамгийн

үнэт зүйл, үнэлэмжтэй нийцэж байгаа эсэхийг мэдэх, асуух эрхтэй байх явдал юм. Энэтхэгийн иргэд өөрийн улсын кастын тогтолцоо буюу нийгмийн хатуу шатлал бүхий тогтолцоог ёс суртахууны хувьд зөв үү гэдэгт эргэлзэж байна гэж бодъё. Тэгвэл хийх ёстой зүйл бол энэ тогтолцоо нь нийгмийн ёс суртахууны хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг асуух явдал юм.

4. Тухайн нийгэмд ёс суртахууны хэвшиж тогтсон хандлага нь зарим тохиолдолд хөгжил дэвшлийн санааг эргэлзээтэй байдалд оруулдаг. Илүү дэвшилтэд байдалд хүрэхийн тулд нийгмийн өөрчлөлт хийхийг хүсдэг. Жишээлбэл, эмэгтэйчүүдийн эрхийн тухай асуудал энд хамаарна. Эмэгтэйчүүд өмчтэй байх, сонгуульд оролцох, улс төрийн албан тушаал хаших боломжгүй зэрэг алаглах явдал нь бодитой оршин байсан бөгөөд хэвшиж тогтсон энэхүү хоцрогдсон хандлагыг хүний үндсэн эрх, хувь хүний нэр төр, үнэ цэнийг дээдэлсэн ёс суртахууны эрхэм дээд чанараар тунхаглаж халсан байдаг.

Дүгнэлт

Өгүүлэлд авч үзсэн агуулгыг багцлан дүгнэлт хийвэл дараах зүйлсийг соёлын релятивистууд онцолдог гэж хэлж болохоор байна. Үүнд:

Нэгдүгээрт, янз бүрийн нийгэм өөр өөр ёс суртахууны хэм хэмжээтэй байдаг.

Хоёрдугаарт, нийгмийн ёс суртахууны хэм хэмжээ нь тухайн нийгэм дотор юу зөв болохыг тодорхойлдог. Өөрөөр хэлбэл, нийгмийн ёс суртахууны хэм хэмжээ нь тодорхой нэг үйлдлийг зөв гэж үздэг бол

тэр үйлдэл нь тухайн нийгмийн хүрээнд зөв болно гэсэн үг юм.

Гуравдугаарт, нэг нийгмийн кодыг нөгөөгийнхөөс илүү сайн гэж дүгнэх объектив стандарт байхгүй. Бүх нийтэд түгээмэл байдаг ёс суртахууны үнэн гэж байдаггүй.

Дөрөвдүгээрт, тодорхой нэг нийгэм дэх ёс суртахууны хэм хэмжээ нь түгээмэл шинжтэй биш.

Тавдугаарт, бусад соёлыг шүүх нь биеэ тоосон байдлыг илтгэнэ. Хүн төрөлхтөн нэг нэгэндээ үргэлж хүлээцтэй байж, ялгаатай байдлыг ойлгодог байх ёстой.

Ямар ч үндэстэн өөрийн онцлогийг хадгалсан соёлыг бүтээж ирсэн. Тиймээс олон соёлын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, хүлээцтэй хандаж хүндэтгэж сурах нь нэг талдаа зүйтэй. Гэхдээ соёлын “хэт өөр” байдлыг хүлээн зөвшөөрвөл зарим талаараа нийгмийн тогтвортой байдал, шударга ёс алдагдаж, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх аюултай. Өөрөөр хэлбэл, “соёлын онцлог” нэрэн доор аймшигтай зан үйлийг хийгээд байж болохгүй. Өөрөөр хэлбэл, соёлын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрдөг байснаараа тэрхүү үйлдэгдэж буй гаж, буруу зан заншлын хажуугаар дуугүй өнгөрч болохгүй юм. Жишээ нь, боолчлол, “гэрлэхээс өмнө бэлгийн харьцаанд орсон хэмээн чулуугаар цохиж алах”², “эмэгтэйчүүд үс гээгээ ил гаргасны төлөө шийтгэл амсдаг байх”³, охидын бэлэг эрхтнийг зэрэмдэглэх зэрэг зан үйлийг ёс зүйн болоод хууль эрх зүйн аль хүрээнд хүлээн зөвшөөрч болохгүй. Тиймээс аль ч нийгэмд нэгэн утгаар ойлгогдох хүмүүнлэг энэрэнгүй, тэгш шударга, хүчирхийллээс ангид байх, үл ялгаварлан гэх мэт ёс

багадаа 3000 хүн энэ үеэр амь үрэгджээ. Тэгвэл НАТО-гийн тагнуулын мэдээлэлд энэ тоог 7000 давсан гэж дурдсан байдаг.

2 2002 онд Нигерт болсон үйл явдал

3 2022 оны 9 сард Иранд болсон үйл явдал

суртахууны түгээмэл зарчмууд үйлчлэх ёстой.

Ёс зүйн релятивизм нь ёс суртахууны үнэлэмж нь соёл, нийгэм, хувь хүний үзэл баримтлалтай харьцангуй холбоотойгэдгийг нотолж, ёс суртахууны нийтлэг түгээмэл хэм хэмжээний тухай ойлголтыг эсэргүүцдэг. Энэ онол нь ёс суртахууны итгэл үнэмшил, дадал зуршлын олон янз байдлыг хүлээн зөвшөөрдөг ч хүн төрөлхтөнд хэн байхаас үл хамаарч хаа ч үйлчлэх ёс суртахууны нийтлэг хэм хэмжээ, зарчмыг үл ойшоодог хэмээн шүүмжлэгддэг. Иймээс өнөөдөр ёс суртахууны маргаантай зарим асуудалд тодорхой хариултыг хүлээн энэ талаарх хэлэлцүүлэг үргэлжилсэн хэвээр байна.

Ном зүй

1. Ч.Баярчимэг, М.Золзаяа, Д.Оюунгэрэл. Монголчуудын амьтныг хамгаалах ёс суртахууны уламжлал ба орчин үе. УБ., 2020.
2. Barbara MacKinnon, Andrew Fiala. Ethics Theory and Contemporary Issues. 2018
3. Russ Shafer-Landau. The Fundamentals of Ethics. 2014
4. James Rachels. The Elements of Moral Philosophy. 1998
5. Этика. Энциклопедический словарь. М., 2001
6. RemleyHerlihy. Ethical, Legal, and Professional Issues in Counseling (2016).
7. Jacques Thiroux and Keith Krasemann. Ethics: theory and Practice. 9-th edition, 2006.
8. John Deigh. An Introduction to Ethics. Cambridge University press. 2011
9. Singer, Peter (1993). Practical Ethics. Cambridge University Press.
10. Singer, Peter (1986). Applied Ethics. Oxford University Press.
11. Wiley Blackwell. Contemporary Debates in Applied Ethics. 2014

Abstract

According to ethical relativists, different cultures have different moral codes. They point out that something regarded as morally wrong in one culture may be morally praiseworthy in other cultures. In other words, the same action may be morally right in one society but be morally wrong in another. We can understand the appeal of cultural relativism, then, despite its shortcomings. Moreover, keeping this thought in mind is important if we want to avoid arrogance and be open to new ideas. These are important points, not to be taken lightly. But we can accept them without accepting the whole theory.